

## СЭМҮТ-ийн 2014 оны тэргүүн туршлага, ололт амжилт

№	Чанарын багууд	Тэргүүн туршлага, ололт, амжилт
1	<b>I клиник</b>	“Өвчний түүх, амбулаторийн карт хөтлөлт” – ийн удирдамж зааврыг хэвлүүлэн СЭМҮТ-ийн клиник бүрт сургалт хийж, тараасан.
2	<b>II клиник</b>	Эмийн жорыг стандартын дагуу бичих зааврыг СЭМҮТ-ийн нийт эмч нарт тараасан. Эмчилгээний заалтыг зөв бичих талаар зөвлөмж гаргасан.
3	<b>III клиник</b>	“Эмийн гаж нөлөө илэрсэн өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээ” сэдвээр СЭМҮТ-ийн нийт эмч, сувилагч нарт сургалт явуулсан.
4	<b>Эмийн сан</b>	“Шинэ сэтгэцэд нөлөөт шинэ үеийн эмүүдийг практикт нэвтрүүлсэн үр дүн” сэдвээр СЭМҮТ-ийн нийт эмч нарын дунд сургалт явуулсан.
5	<b>IV клиник</b>	“Туслах сувилагчийн ажил үүргийн хуваарь” (Анхаарах, үүд, гал тогоо хариуцсан туслах сувилагчийн үүрэг хариуцлага) сэдвээр СЭМҮТ-ийн нийт туслах сувилагч, сувилагч нарт мэдээлэл хийж ажлын байрны зураглалыг гаргасан.
6	<b>Эрүүл ахуй халдвар хяналтын баг</b>	“Халдвар-хяналтын тогтолцоо, эмнэлгийн халдваргүйтгэл ариутгал тасгийн үйл ажиллагаатай уялдах нь” сэдвээр СЭМҮТ-ийн нийт эмч, ахлах сувилагч нарт мэдээлэл хийсэн.
7	<b>V клиник</b>	“Шизофрени өвчнийг эмчлэхэд хэрэглэхэд орчин үеийн эмчилгээ ба ар гэрт өгөх зөвлөмж” /оношлогоо эмчилгээ, сувилахуйн тусламж, асаргаа, ар гэрийнхэнд өгөх зөвлөмж/ сэдвээр СЭМҮТ-ийн нийт эмч нар болон эмчлүүлэгчдийн ар гэрт сургалт явуулж тараах материал хэвлүүлсэн.
8	<b>Сэтгэл эмчилгээний баг</b>	“Ажлын байрны стресс менежмент” сэдвээр сургалт зохион байгуулсан. СЭМҮТ-ийн нийт ажилчдаас 10 сарын 13-15 хооронд ажлаас халшрах хам шинжийг үнэлэх асуумж судалгаа авсан. Судалгааны үр дүнг “Ажлын байрны стресс менежмент” сургалтанд танилцуулан мэдээлэл хийж, тараах материал хавсарган өгсөн.
9	<b>VI клиник</b>	“Эмийн зохистой хэрэглээ” сэдвээр СЭМҮТ-ийн нийт клиникт хэвтэн эмчлүүлж буй эмчлүүлэгч нар болон амбулаториор үйлчлүүлэгч нар, тэдний ар гэрийнхэн, эмнэлгийн нийт ажилчдад зориулж мэдээлэл хийсэн.
10	<b>ШСЭСК</b>	“Тасаг доторх сэргээн засах эмчилгээ” сэдвээр СЭМҮТ-ийн сувилагч, туслах сувилагч нарт мэдээлэл хийн, тараах материал тараасан.
11	<b>Хүүхэд өсвөр үеийн клиник</b>	“Компьютер тоглоомын зохистой хэрэглээ” сэдвээр СЭМҮТ-ийн нийт эмч нар болон эмнэлгийн ажилчдын

дунд компьютер тоглоомын хэрэглээний түвшинг илрүүлэх аргад суралцуулан сургалт хийн, гарын авлага тарааж өгсөн.

12	<b>Донтох эмгэг судлалын клиник</b>	“Танин мэдэхүй, зан үйлийн сэтгэл засал, Миннесота загвар эмчилгээ”-г СЭМҮТ-ийн нийт эмч, сувилагч, туслах сувилагч нарт сургалт зохион байгуулсан.
13	<b>Асрамжийн клиник</b>	“Эмч, эмнэлгийн мэргэжилтэн хоорондын харилцааны горим, хэм хэмжээ” сэдвээр СЭМҮТ-ийн нийт эмч, эмнэлгийн ажилтнуудад сургалт явуулсан.
14	<b>Яаралтай тусламжийн тасаг</b>	“Эмийн зохистой хэрэглээ”-ний зөвлөмж /эмийн хэрэглээ, хяналт, ар гэрийнхний анхаарал халамж/ сэдвээр СЭМҮТ-өөр үйлчлүүлж буй нийт үйлчлүүлэнч нар, эмчлүүлэгч нарт нээлттэй өдөрлөг явуулсан.
15	<b>Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний тасаг</b>	“Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээ”- ний удирдамжийг шинээр боловсруулан практик хэрэглэж байна. Сэргээн засах эмчилгээний технологийг шинээр нэвтрүүлсэн. СЭМҮТ-ийн нийт эмч, эмнэлгийн ажилчид болон эмчлүүлэгч тэдний ар гэрийнхэн, хэвлэл мэдээллийн салбарт нэг өдрийн нээлттэй өдөрлөг явуулсан. Энэ өдөрлөгийн үеэр <b>Сэтгэц нийгмийн сэргээн засах эмчилгээний үйл явцыг сурталчилан таниулж, эмчлүүлэгч тэдний ар гэрийнхэний хэрэгцээг судалсан судалгаа хийсэн.</b>
16	<b>Сэргээн засах, физик эмчилгээний тасаг</b>	Гэмтэл, стресс болон донтох эмгэгийг эмчлэх “Чихний зүү эмчилгээ” –г практикт нэвтрүүлсэн. Эмчилгээний үр дүнг тооцож судалгаа хийсэн.